

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшин тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Хүлээн авах хаяг: bayanzurh@ndaatgal.mn цахим шуудангаар
- Холбоо барих утас: 91117411

Шилжүүлэн ажиллуулах ажлын байрны жагсаалт:

д/д	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын		Хариуцах асуудал	Орон тоо	Албан тушаалд тавигдах тусгай шаардлага				
			Ангилал	Нэр			Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дэс түшмэл ТЗ-8	Сайн дурын даатгалын байцаагч, мэргэжилтэн	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, хамралтыг нэмэгдүүлэх, даатгуулагчдын мэдээллийн санг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна..	1	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	эдийн засаг /0311/; нягтлан бодох бүртгэл, татвар /0411/; санхүү, банк, даатгал /0412/; менежмент ба удирдахуй /0413/; маркетинг, зар сурталчилгаа /0414/; худалдаа /0416/;		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад.

2	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар	Дэс түшмэл ТЗ-8	Нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэн	Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөвлөгөө мэдээлэл өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн баримтыг цаг хугацаанд нь хүлээн авах, хүсэлт илгээх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.	1	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	эдийн засаг /0311/; нягтлан бодох бүртгэл, татвар /0411/; санхүү, банк, даатгал /0412/; менежмент ба удирдахуй /0413/; маркетинг, зар сурталчилгаа /0414/; эрх зүй /0421/; худалдаа /0416/;		Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад.
---	----------------------------------	--	-----------------	---	---	---	--	---	--	---	---